



СҮХБААТАР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 11

Баруун-Урт

Дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, 20.1.7, 25 дугаар зүйлийн 25.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ нь:

1. "АРХИГҮЙ СҮХБААТАРЧУУДЫН ТӨЛӨӨ" дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийн хүрээнд аймаг, сумдын хэмжээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөө гарган, биелэлт үр дүнг тооцож ажиллахыг Аймгийн Засаг дарга, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Б.МӨНХБАТ

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2018 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн  
11 дугаар тогтоолын хэвсрэлт

## **“АРХИГҮЙ СҮХБААТАРЧУУДЫН ТӨЛӨӨ” ХӨТӨЛБӨР**

### **НЭГ.ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ**

“Архигүй Сүхбаатарчуудын төлөө” хөтөлбөр нь Монгол Улсын Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангах, Сүхбаатар аймгийн ард иргэдийг архигүй, эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг нэмэгдүүлж, архидан согтуурахтай тэмцэх, эрүүл аж төрөх заншил төлөвшүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, олон нийт иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ.

Монгол Улсын насанд хүрсэн нэг хүнд 48,5 литр архи ноогддогийн сацуу насанд хүрсэн хүн амын 51,2 хувь нь архины хамааралд өртөж, эрэгтэйчүүдийн эрэгтэйчүүдийн 5 хувь нь архинд донтох эмгэгтэн болсон нь мэргэжлийн байгууллагын судалгаагаар нотлогдсон.

Сүхбаатар аймгийн хэмжээнд сум дундын шүүхээр шийдвэрлэгдсэн хэргээс согтуугаар гэмт хэрэг үйлдэгсэд 2014 онд 32.6%, 2015 онд 28.7%, 2016 онд 39.5% болж өссөн байна.

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 2016 оны байдлаар 109 бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 15 нэгжээр буюу 13,7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Архидалт нь ажилгүйдэлтэй холбоотойгоор ахуйн хүрээнд архидан согтуурах явдал иргэдийн дунд түгээмэл байна.

Иймд архидалтаас үүдэн үйлдэгдэн гарч байгаа гэмт хэрэг зөрчил, хүний эрүүл мэнд, гэр бүл, хамт олон, нийгмийн амьдралд учрах хор уршиг ихсэх хандлагатай байгаа тул архины хамааралтай иргэдийг эрт илрүүлж, урьдчилан сэргийлэх, эмчлэх, эргээд нийгэмдээ тустай иргэн болгон төлөвшүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, иргэдийн эрүүл аюулгүй орчинд аж төрөх эрхийг хангах, амгалан тайван байдлыг хамгаалах зорилгоор энэ хөтөлбөрийг аймгийн хэмжээнд боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

### **ХОЁР.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХУГАЦАА**

#### **2.1.Хөтөлбөрийн зорилго**

Архидан согтуурснаас үүдэн гарч буй гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, архинаас хамааралтай хүн амын эрүүл мэнд, нийгэмд үүсэж буй сөрөг үр дагавруудыг арилгах, ард иргэдийнхээ амгалан тайван байдлыг хангах үүднээс төрийн болон төрийн бус, олон нийтийн байгууллагууд, иргэдийн идэвх санаачилга, оролцоог нэмэгдүүлэн, тэдгээрийн хамтын уялдаа холбоог бий болгон, архигүй аймаг, сум, баг, байгууллага, хувь хүн цаашилбал АРХИГҮЙ МОНГОЛ байхын төлөө үйлсийг хэрэгжүүлэхэд “АРХИГҮЙ СҮХБААТАРЧУУДЫН ТӨЛӨӨ” хөтөлбөрийн зорилго оршино.

#### **2.2.Хөтөлбөрийн зорилт**

2.2.1. “Архигүй Сүхбаатарчуудын төлөө” хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх, иргэд олон нийтэд хандсан нөлөөлөл, мэдээлэл, сурталчилгааны ажлуудыг зохион байгуулах.

2.2.2. Архины хамааралтай болсон иргэдийн талаар дэлгэрэнгүй судалгааг гарган, түүнд дүгнэлт хийх.

2.2.3. Өөрөө архианаас гарах сэдэлттэй, архины хамааралтай иргэдийг энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага болон эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран сургалт, эмчилгээнд гэрээний үндсэн дээр хамруулж, холбогдох зардлыг орон нутгийн төсвөөс хариуцан дэмжлэг үзүүлэх.

2.2.4. Сургалт, эмчилгээнд хамрагдаж архины хамаарлаас ангижирсан иргэдийг мэргэжил олгох болон мэргэшүүлэх сургалтуудад хамруулан мэргэжил эзэмших нөхцөл бололцоогоор хангах.

2.2.5. Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст ажил олгогчоос ирүүлсэн ажлын байрны захиалгын дагуу сургалтад хамрагдаж архины хамаарлаас гарсан иргэдийг ажилд зуучлах, хөнгөлттэй зээл тусламж, төсөл хөтөлбөрт хамруулах.

### **2.3. Хөтөлбөрийн хугацаа**

Хөтөлбөрийг 2018-2021 он хүртэл хэрэгжүүлнэ.

## **ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТОД ХҮРЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛҮҮД**

### **3.1 Архины хамааралтай иргэдийн дэлгэрэнгүй судалгааг гаргах чиглэлээр**

3.1.1. Аймгийн хэмжээнд архины хамааралтай иргэд, архаг архичдын дэлгэрэнгүй судалгааг гаргах /Нас хүйс, боловсрол мэргэжил, сургалт, эмчилгээнд хамрагдах сонирхолтой эсэх, хэрхэн хамруулах, хамрагдах иргэдийн тоо гэх мэт бусад судалгааг гаргах/

3.1.2. Судалгааны үндсэн дээр зорилтот жилүүдэд архины хамаарлаас ангижрах иргэдийн судалгааг нарийвчилсан бүртгэл хийх.

3.1.3. Тухайн жилд хамрагдах иргэдтэй гэрээ байгуулах

### **3.2. Архины хамааралтай иргэдийг сургалт арга хэмжээ, эмчилгээнд хамруулах чиглэлээр**

3.2.1. Архины хамаарал бүхий иргэдийн хандлагыг өөрчлөх, архины хамаарлаас ангижрах, эрүүл зөв амьдрах чиглэлээр лекц, сургалт, уулзалт ярилцлага зохион байгуулах

3.2.2. Архины хамаарлаас ангижрах хүсэлтээ гаргасан, гэрээ байгуулсан иргэдийг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын сургалт, сайн дурын эмчилгээнд хамруулах

3.2.3. Архины хэт хамааралтай иргэдийг холбогдох байгууллагын саналыг үндэслэн албадан эмчилгээнд хамруулах, санхүүгийн асуудлыг шийдвэрлэх /Төв аймгийн Баян суманд байрлах Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий газрын харьяа албадан эмчлэх төвд эмчилгээнд хамруулах/

3.2.4. Архины хор хөнөөл, архидан согтуурахын хор уршиг, хэрэглээний талаар нийт хүн амын мэдлэгийг дээшлүүлэх талаар сумдад бүсчилсэн сургалт зохион байгуулах

### **3.3. Сургалт, эмчилгээнд хамрагдсан иргэдийг эрэлт хэрэгцээ ихтэй мэргэжлийн сургалтуудад хамруулан мэргэжил эзэмших нөхцөл бололцоогоор хангах чиглэлээр**

3.3.1. Архины хамаарлаас гарсан болон албадан эмчилгээнд хамрагдсан иргэдийг гагнуурчин, мужаан, сийлбэрч, барилгын засал чимэглэлч, сантехникч, жолооч гэх мэтийн мэргэжил олгох сургалтад хамруулан мэргэжил эзэмшүүлэх

3.3.2. Мэргэжил олгох сургалтуудыг аймгийн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн материаллаг бааз суурь дээр түшиглэн оновчтой зохион байгуулах.

3.4. Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст ажил олгогчоос ирүүлсэн ажлын байрны захиалгын дагуу сургалтад хамрагдаж архины хамаарлаас ангижирсан иргэдийг эхний ээлжид ажилд зуучлах, хөнгөлттэй зээл тусламж, төсөл хөтөлбөрт хамруулах чиглэлээр

3.4.1.Төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудын удирдлагын түвшинд “Архигүй Сүхбаатарчуудын төлөө” хөтөлбөрийг танилцуулах, ажлын байрны захиалгад архины хамаарлаас гарсан болон архины албадан эмчилгээнд хамрагдсан иргэдийг нэн тэргүүнд ажилд зуучлах талаар зөвлөлдөх уулзалт зохион байгуулах.

3.4.2.Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас аймаг орон нутагт хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрт дээрх иргэдийг хамруулах асуудлыг судалж шийдвэрлэх

3.4.3.Архины хамаарлаас гарсан иргэдийг бүлэг болгон жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж хөнгөлттэй зээл олгох, тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулах

3.4.4. Хөтөлбөрт хамрагдсан иргэдийн ажлын байрны судалгааг жил бүр нэгтгэн гаргах.

**3.5.Холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудын хүлээх үүрэг, хамтын ажиллагааны чиглэлээр**

### **3.5.1.Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль,эрх зүйн хэлтэс**

1.Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль тогтоомж, шийдвэрүүдийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд ханган ажиллах талаар төрийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлж, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх

2.Архидан согтууралтай тэмцэх хууль тогтоомж, дүрэм журмыг боловсронгуй болгох, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тулгарч байгаа асуудлын талаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын дунд нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулах.

3. Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр орон нутгийн төрийн байгууллагуудаас гаргаж буй шийдвэрүүдийн төслүүдийг боловсруулахад арга зүйн туслалцаа үзүүлэх

4. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгох нийтлэг журмыг боловсронгуй болгож мөрдүүлэх, тавих шаардлагыг өндөржүүлэх

### **3.5.2. Сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга**

1.Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны чиглэлд нийцүүлэн орон нутгийн онцлог, тулгамдсан асуудалд тулгуурласан дэд хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих

2.Сум хөгжүүлэх сангаас олгож буй хөнгөлттэй зээлэнд архины хамааралтай сургалт, эмчилгээнд хамрагдсан иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах /Батлан даалтын гэрээг байгуулж өгөх/

3.Архи хэрэглэдэггүй хүмүүсийн туршлага, зөвлөгөөг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг тогтмолжуулах, тэдний оролцоотойгоор архидан согтуурахаас сэргийлэх олон нийтийн байгууллага байгуулж ажиллах үүсгэл санаачилгыг бүх талаар дэмжих

4.Архинд донтох өвчтэй хүнийг сайн дураар нь хаяггүй эмчилгээнд хамруулах, зайлшгүй шаардлагатай тохиолдолд албадан эмчлэх ажлыг зохион байгуулах, архинаас гарах эмчилгээ хийлгэсэн хүмүүсийн ахуй амьдралд туслах, ажлын байраар хангах арга хэмжээ авч байх

5.Архидан согтуурахаас сэргийлэх талаар тодорхой ажил зохион үр дүнд хүрсэн байгууллага, хамт олонд дэмжлэг үзүүлэх, тэдний үйл ажиллагааг сурталчлах, урамшуулах

6.Байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дүгнэхдээ архидан согтуурахаас сэргийлэх талаар хийсэн ажил, түүний үр дүнг нэг үзүүлэлт болгон сайн ажилласан байгууллага, хамт олныг дэмжин урамшуулж байх



### **3.5.3.Цагдаагийн газар**

1.Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль тогтоомж, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах, архидалтаас үүдэн гарсан гэмт хэрэг, зөрчлийн байдалд дүн шинжилгээ хийж хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг мэдээллээр хангах

2. Архины хамааралтай иргэдийн судалгааг жил бүр шинэчлэн гаргах

3.Архидан согтуурсны улмаас биеэ авч явах чадваргүй болсон хүнийг албадан эрүүлжүүлэх, баривчлах байрны нөхцөл, үйлчилгээг сайжруулах, иргэдэд зөвлөгөө өгөх, сургалт хийх ажлыг тогтмолжуулах

4.Архи хэтрүүлэн хэрэглэгч, архинд донтох өвчтэй иргэдийн судалгааг гарган, албадан эмчилгээнд хамруулах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах

5.Архидан согтуурсны улмаас гэмт хэрэг, зөрчилд удаа дараа холбогдсон иргэдийн судалгааг гаргаж, гэр бүл, хамт олонтой нь хамтарч, дахин гэмт хэрэг зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлж ажиллах.

6. Согтууруулах ундааны худалдаа, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд холбогдох хяналтын байгууллагуудтай хамтран цэгийн тоонд хяналт тавих, шалгалт хийх, зөвлөмж, зөвлөгөө өгөх.

### **3.5.4.Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар**

1.Архины хамааралтай сургалт, албадан эмчилгээнд хамрагдсан иргэдийг сургаж мэргэшүүлэх ажлын байраар хангах, хөдөлмөрийн зохицуулалт хийх

2.Архины хамаарлаас ангижирсан иргэдийг нийгмийн халамжийн болон хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөр, зээл тусламжид хамруулах

3.Орон гэргүй тэнэмэл, архины хамаарлаас гаргах сургалт, албадан эмчилгээнд хамрагдсан иргэдийг гэр оронтой болгох, бусад төрлийн нийгмийн халамжийн дэмжлэг тусламжаа үзүүлэх, хөрөнгийн эх үүсвэрийг орон нутгийн төсөвт суулгуулах арга хэмжээг шуурхай авч ажиллах

### **3.5.5.Эрүүл мэндийн газар**

1.Архинд донтох өвчнийг эрүүл мэндийн суурь тусламжийн хүрээнд эрт илрүүлэх, эмчлэгдсэн хүнийг хяналтад авах арга хэмжээг зохион байгуулах

2.Согтууруулах ундааны хор нөлөө, архинд донтох өвчний талаар хүүхэд, залуучууд, нийт хүн амын дунд явуулах эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааг өргөжүүлэх, энэ чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, арга зүйн зөвлөгөө өгч ажиллах

3.Наркологийн албыг бэхжүүлж, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бүтэц, зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх

4.Архинд донтох өвчнийг эрт илрүүлэх, эмчлэх, нөхөн сэргээх талаар эмч, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх.

5.Архинд донтох өвчний үед үзүүлж буй эмчилгээний үр дүнг судлах

6.Архинд донтох өвчинг эрт илрүүлэх, эмчлэх, урьдчилан сэргийлэх талаар аргачлал, удирдамж боловсруулан эрүүл мэндийн байгууллага, эмч, эмнэлгийн ажилтнуудад мөрдүүлэх.

### **3.5.6. Мэргэжлийн хяналтын газар**

1.Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, түүнийг хэрэгжүүлэх чиглэлээр гарсан бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих

2.Согтууруулах ундааны үйлдвэрлэл, тээвэрлэлт, хадгалалтын технологи, стандарт, чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлыг хянан холбогдох арга хэмжээг авч байх;

3.Согтууруулах ундаа худалдан борлуулдаг, үйлчилгээ үзүүлдэг, аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх

4.Архины хамааралтай этгээдэд хууль эрхзүй, эмнэлгийн тусламж үзүүлж буй байгууллагын эрүүл ахуйн нөхцөл, эмчилгээний чанарыг сайжруулахад мэргэжил, аргазүйн туслалцаа үзүүлэх, хяналт тавих

### **3.5.7.Стандарт, хэмжил зүйн хэлтэс**

1.Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн №159 тоот Техникийн зохицуулалтын тухай” тогтоолыг хэрэгжүүлэх.

2.Архи согтууруулах ундаа худалдах, үйлчилгээ үзүүлж байгаа аж ахуйн нэгжийн ажлын байранд Монгол Улсын MNS 4946:2005 “Хоолны газрын ерөнхий шаардлага, MNS 5021:2007 “Худалдааны газрын ерөнхий шаардлага стандартуудын мөрдөлтийг шалгах Тохирлын гэрчилгээг нэвтрүүлэх.

3. Согтууруулах ундаа худалдан борлуулдаг, худалдаа, үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгжид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх стандартын сургалт зохион байгуулах.

4. Согтууруулах ундаа худалдан борлуулдаг, худалдаа, үйлчилгээ үзүүлдэг аж ахуй нэгжид Монгол Улсын стандартаар үйлчлэх техникийн зохицуулалт, стандартыг түгээн дэлгэрүүлэх сурталчлах.

### **3.5.8.Хэвлэл мэдээллийн байгууллага**

1.Архидан согтуурснаас нийгэм, эдийн засаг, хувь хүний ёс зүй, бие, сэтгэцэд учрах хор уршгийн талаар нийт хүн ам, ялангуяа хүүхэд өсвөр үеийнхэнд тодорхой дэс дараатай мэдлэг, хандлага, зөв зан үйлийг эзэмшүүлэхэд чиглэсэн мэдээ, мэдээлэл, сургалт, сурталчилгааг нийтлэл, нэвтрүүлгийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөртөө тусгах, цагийг нэмэгдүүлэх, захиалагчдад хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх

2.Хүний эрүүл мэндэд хортой согтууруулах ундааны хэрэглээг дэмжин борлуулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн зар сурталчилгааг радио, телевизээр нэвтрүүлэхгүй, хэвлэл /сонин, сэтгүүл/-д нийтлэхгүй, санамж, зурагт хуудас, гудамжны самбараар сурталчлахгүй байх, хүний эрүүл мэндэд ашиг тустай хүнсний бүтээгдэхүүний зар сурталчилгааг дэмжих бодлого баримталж ажиллах

3. “Архигүй Сүхбаатарчуудын төлөө” хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохиож буй ажлын ололт, архины хамаарлаас ангижирсан иргэдийг олон нийтэд тухай бүр нийтэд сурталчилж, мэдээлэх ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх

### **3.5.9.Төрийн бус байгууллага**

1.Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны чиглэлийг хэрэгжүүлэхэд өөрсдийн зүгээс идэвхтэй оролцох, бусад байгууллагуудтай хамтран үр ашигтай ажиллах, дэмжлэг туслалцаа үзүүлэх

### **3.5.10.Аж ахуйн нэгж байгууллага**

1.Аж ахуйн нэгж байгууллагууд нийгмийн хариуцлагын хүрээнд “Архидан согтууралтай тэмцэх, урьдчилан сэргийлэх сан”-д архи согтууруулах ундаа худалдан борлуулсан ашгийн тодорхой хувийг төвлөрүүлэх, мэргэжлийн сургалтад хамрагдсан ажил идэвхтэй хайж байгаа иргэдийг ажлын байраар хангах

2. “Архигүй орчин, архидалтгүй хамт олон” уриан дор аливаа баяр ёслол, тэмдэглэлт өдрийг архигүй тэмдэглэх, архины хор хөнөөлийн талаар сургалт зохион байгуулах, ажилтнуудаа хамруулах, аяныг зохион байгуулах

## **ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТ**

### **4.1.Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт**

4.1.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг хариуцан, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллана.

4.1.2. Сумдад хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах ажлыг Засаг даргын томилсон ажлын хэсэг хариуцна.

4.1.3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих үүргийг хэрэгжүүлнэ.

### **4.2. Хөтөлбөрийн санхүүжилт**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүжилт нь доорх эх үүсвэрүүдээс бүрдэнэ.

4.2.1. Орон нутгийн төсвийн орлого

4.2.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1-т зааснаар “Тухайн жилд шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон, торгох ял ногдуулж төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулан зарцуулна,

4.2.3.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тусгай зөвшөөрлийн улсын тэмдэгтийн хураамжаар орон нутгийн төсөвт төвлөрсөн хөрөнгийн 20%-тай тэмцэх хэмжээгээр төлөвлөж, архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд зарцуулна.

4.2.4. Бусад орлогоос

## **ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН, ХЭРЭГЖИЛТИЙГ ДҮГНЭХ, ТАЙЛАГНАХ**

### **5.1. Хүрэх үр дүн**

5.1.1.Архины хамааралтай иргэдийн талаар дэлгэрэнгүй судалгаатай болно.

5.1.2.Архины хамаарлаас ангижрах сургалт арга хэмжээ, эмчилгээнд хамрагдах иргэдийн оролцоо сайжирч, архины хор хөнөөлийн талаар иргэдийн ойлголт сайжирна.

5.1.3. Аймгийн хэмжээнд архидан согтуурал, архины хамааралтай иргэдийн тоо хэмжээ буурч, архинаас үүдэлтэй үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлийн тоо багассан байна.

5.1.4.Аймгийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн түвшин тодорхой хувиар өсөж өрхийн орлого нэмэгдсэнээр ажилгүйдэл ядуурал гэсэн нийгмийн сөрөг үзэгдлүүд буурна.

5.1.5. Иргэдийн эрүүл аюулгүй, цэвэр орчинд амьдрах таатай нөхцөл бүрдсэн байна.

### **5.2.Тайлагнах, дүгнэх**

5.2.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар чиг үүрэг хүлээсэн байгууллагын удирдах албан тушаалтан бүр зохиосон ажил, хүрсэн үр дүнг хагас жилээр 6 дугаар сарын 15, жилээр 12 дугаар сарын 15 -ны дотор хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий аймгийн ажлын хэсэгт ирүүлж байна.

5.2.2.Аймгийн ажлын хэсэг нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан ажлын дүнг нэгтгэн дүгнэж Засаг даргын Зөвлөлийн хуралдаанаар уламжлан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж байна.

**“АРХИГҮЙ СҮХБААТАРЧУУДЫН ТӨЛӨӨ” ХӨТӨЛБӨРИЙГ  
2018 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Нэг: Хөтөлбөрийн бэлтгэл ажлын төлөвлөгөө:

д/д	Үйл ажиллагаа	Цаг хугацаа	Төсөв	Хариуцах эзэн	Хамтран ажиллах
1.	Хөтөлбөрийн анхны төслийг боловсруулах.	2018 оны 01 сард	-	Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад Г.Ганчимэг	Хууль, эрх зүйн хэлтэс
2.	Хөтөлбөрийг Аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулах.	2018 оны эхний улиралд	-	Цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэд хурандаа Т.Ганзориг, Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад Г.Ганчимэг	Хууль, эрх зүйн хэлтэс
3.	Төсөл хөтөлбөрийг Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулах.	2018 оны эхний хагас жилд	-	Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахмад Г.Ганчимэг	Хууль, эрх зүйн хэлтэс

Хоёр: Хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө /2018 он/

д/д	Үйл ажиллагаа	Цаг хугацаа	Төсөв	Хариуцах эзэн	Хамтран ажиллах
1.	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулах.	2018 оны 12 дугаар сарын 01-10-ны дотор	-	Аймгийн Засаг дарга	АЗДТГазар
2.	“Архигүй Сүхбаатарчуудын төлөө” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж ажлын хэсгээр батлуулах.	2017 оны 12 дугаар сарын 01-10-ны дотор	-	Ахмад Г.Ганчимэг	Ажлын хэсэг
3.	Хөтөлбөрийн хүрээнд “мэргэжилтний хамтарсан баг” байгуулах.	2018 оны 05 дугаар сарын 10-10-ны дотор	-	Ахмад Г.Ганчимэг	АЗДТГазар
4.	Аливаа баяр ёслол, олон нийтийн арга хэмжээг архи согтууруулах ундаагүй тэмдэглэн өнгөрүүлэхийг шийдвэр гаргагч нараас үлгэрлэн “Уриалга”	2018 оны 06 дугаар сарын 01-ний дотор		Ажлын хэсэг, Мэргэжилтний баг	ИТХ, АЗДТГазар



	гаргуулах.				
5.	"Архигүй байгууллага, хамт олон" бий болгох Challenge цахим орчинд өрнүүлэх.	2018 оны эхний хагас жилд	-	Ажлын хэсэг,	Мэргэжилтний баг
6.	Архидан согтуурах, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр "Дэвжээ" тэмцээнийг зохион байгуулах.	2018 оны эхний хагас жилд	1,500,000	Ажлын хэсэг,	Мэргэжилтний баг
7.	"Архигүй Сүхбаатарчуудын төлөө" хөтөлбөрийг сурталчлах, иргэд олон нийтэд архигүй амьдрах илтгэл үнэмшлийг олгох зорилгоор богино хэмжээний шторк, реклам, нэвтрүүлэг бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах.	2018 оны эхний хагас жилд	500,000	Ажлын хэсэг,	Мэргэжилтний баг
8.	Олон нийтийг архигүй амьдралд уриалсан "Архигүй Сүхбаатарчуудын төлөө" гэсэн самбар, тараах материал хэвлүүлэх, байрлуулах.	2018 оны эхний хагас жилд	1,500,000	Ажлын хэсэг,	Мэргэжилтний баг
9.	Сүхбаатар аймгийн томоохон цахим сайт, группүүдэд архины хор хөнөөл, архигүй Сүхбаатар дэд хөтөлбөрийн талаарх эерэг мэдээллүүдийг тогтмол байрлуулж ажиллах.	Жилдээ	-	Ажлын хэсэг,	Мэргэжилтний баг Төрийн болон төрийн бус байгууллагууд
10.	Сум, баг, байгууллага хамт олон бүр хамт олныхоо дунд архинд хандах хандлагын талаар нөлөөллийн ажил, сургалтуудыг зохион байгуулах.	Улирал тутам	2,000,000	Ажлын хэсэг,	Сумдын ГХУСАЗСЗ, Засаг дарга, байгууллагын дарга, эрхлэгч, захирал
11.	Аймгийн хэмжээнд архины хамаарал бүхий иргэдийн судалгааг гаргах.	2018 оны эхний хагас жилд	-	Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар	Ажлын хэсэг
12.	Ахуйн хүрээнд архидалт зохион байгуулдаг айл өрхийн судалгааг гаргах.	2018 оны эхний хагас жилд	-	Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар	Ажлын хэсэг
13.	Архины асуудлаа шийдвэрлэхийг хүссэн иргэд	Жилдээ	3,000,000	Цагдаагийн газар, Эрүүл	Ажлын хэсэг Төрийн бус

	болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд сургалт явуулах			мэндийн газар, ХГБХГазар	байгууллага
14.	Цагдаагийн газрын эрүүлжүүлэх, баривчлах байранд орсон иргэдийн дунд “Чин сэтгэлийн ярилцлага” зохион байгуулж, архины асуудлаа өөрийн хүсэлтээр шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх, хөтөлбөр сургаалтанд хамруулах.	Жилдээ	500,000	Ажлын хэсэг Цагдаагийн газар,	Төрийн бус байгууллага
15.	Хүүхдийн оролцооны байгууллагууд болон “Өсвөрийн сэргийлэгч” бүлгэмийн гишүүдээр үе тэнгийнхэнд нь чиглэсэн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах.	Жилдээ	1,500,000	Ажлын хэсэг Цагдаагийн газар, ХГБХХ	Төрийн бус байгууллага
16.	Архины хамаарал бүхий иргэдийг сайн дурын болон албадан эмчилгээнд хамруулах, АНЭ-ийн наркологийн тасаг хэвтүүлэн, архинд хандах хандлагыг өөрчлөх замаар эмчлүүлэх.	Жилдээ	Өөрсдийнх нь зардлаар	Цагдаагийн газар, ХГБХХ, АНЭмнэлэг	Төрийн бус байгууллага
17.	“Архигүй Сүхбаатарчуудын төлөө” төсөл хөтөлбөрийн хүрээнд сумдад ажиллах	Жилдээ	Аймгийн ГХУСАЗСЗ-өөс	Ажлын хэсэг	Мэргэжилтний баг
18.	“Архигүй Сүхбаатарчуудын төлөө” хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд нэгдсэн зөвлөгөөн зохион байгуулах	2018 оны 2 дугаар улиралд	Аймгийн ГХУСАЗСЗ-өөс	Ажлын хэсэг	Мэргэжилтний баг
19.	Аймгийн хэмжээнд архи согтууруулах ундаа худалдан борлуулах, үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны хуулийн хэрэгжилтийг шалгах.	Улирал тутам	-	Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Стандартчилал хэмжил зүй хэлтэс	Холбогдох бусад төрийн байгууллагууд
20.	“Архигүй Сүхбаатарчуудын төлөө” хөтөлбөрийн хүрээнд архины хор хөнөөлийг сурталчилсан телевизийн нэвтрүүлэг, нийтлэл бэлтгэж иргэд олон нийтэд хүргэх.	Жилдээ	-	Хэвлэл мэдээллийн байгууллагууд	-